



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/384

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 221 дүгээр
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 221 дүгээр цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,508,350.00 (таван сая таван зуун найман мянга гурван зуун тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Чингэлтэй дүүргийн 221 дүгээр цэцэрлэг (М.Алтанцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 6 нэр төрлийн 4,291,350.00 (дөрвөн сая хоёр зуун ерэн нэгэн мянга гурван зуун тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтанд дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 1 нэр төрлийн 1,217,000.00 (нэг сая хоёр зуун арван долоон мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 30,000.00 (гучин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 9,000.00 (есөн мянга) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Чингэлтэй дүүргийн 221 дүгээр цэцэрлэг (М.Алтанцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа

В.ОЮУМАА



1150501152

Нийслэлийн Өмчийн хариуцаж
дэргын 2024 оны 40 дугаар
өдрийн 1334 дугаар тушаал

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн 221-р цэцэрлэг

[illegible]